MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,161,113... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.08.31. Пүрэв. №145 (4759) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +23

Шөнө +9

УЛС ТӨР

ХХААХҮ-ИЙН САЙДЫН НЭРЭМЖИТ ГРАНТАД ШАЛГАРСАН БҮТЭЭЛҮҮДИЙН НЭРС ТОДРОВ

“УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТЕХНОЛОГИ, СУРГАЛТЫН ТӨВ”-ИЙН БАРИЛГЫН ШАВ ТАВИХ ЁСЛОЛ БОЛЛОО

II нүүрт

Дугаарын 60 мөр

## Намрын синдром

Г.ГАНЧИМЭГ

Өнөөдөр хамгийн их үнэд орж байгаа хүмүүс бол бүх шатны сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нар байна. Таньдаг хүнээ ч танихгүй болтлоо хаданд гарчээ, тэд. Эмгэнэлтэй нь гэвэл сургууль, цэцэрлэгийн хашаа, байрны хаалга, бүр цаашлаад ажлын өрөөнийх нь хаалга дотроосоо дангинатал түгжээтэй. Манаач нь хүртэл хамраа сөхчихсөн хүнтэй ямар ч харьцаагүй, юм асуухаар дуугарахгүй эсвэл эгээ л нэг оргодол хулгайчийг барьсан юм шиг хашгичиж загнаад жигтэйхэн. Үнэндээ энэ нь тийм ч шинэ дүр зураг биш. Жилийн жилд наймдугаар сарын сүүлчээр буюу сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд бүртгүүлэх үетэй давхцан Монголд үүсдэг намрын синдром. Өөрөөр хэлбэл, Монголын нийгэм эрүүл биш, өвчтэй байна.

Төгсгөл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# МАН-ЫН УДИРДЛАГУУД ЗӨВШИЛЦӨЛД ХҮРЭЛГҮЙ “ҮЗЭЛЦЭХЭЭР” ШИЙДЛЭЭ



Н.ПУНЦАГБОЛД

Засгийн газраа огцруулахаар гарын үсэг цуглуулж байгаа МАН-ын бүлэг өнгөрсөн хоёр өдөр хуралдлаа. Мягмар гарагийн шөнө дөл болтол хуралдахдаа тэд дорвитой шийдэлд хүрээгүй талаар хэвлэлүүд мэдээлж буй. Өмнө нь олон бичлэгээ алдаж хаширсан МАН энэ удаагийн бүлгийн хурлаа нэлээд нууц байдлаар хийлээ. Гэхдээ л зарим гишүүд нь твиттер хаягаараа жиргэж, бусад нь бага сага мэдээлэл хэвлэлийнхэнд өгсөн.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# ЕСДҮГЭЭР САРЫН 01-НД “ЭХ ХЭЛНИЙ ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭНЭ

Э.ТУУЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга бүх нийтэд хандсан анхны зарлигаа гаргаж, жил бүрийн есдүгээр сарын 01-ний өдрийг “Эх хэлний өдөр” болгон зарлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын энэ сарын 25-нд гаргасан “Эх хэлний өдөр зарлах тухай” 25 дугаар зарлигийг гардуулах ёслол өчигдөр Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд боллоо. Зарлиг гардуулах ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд, Ерөнхийлөгчийн Соёл, шашны бодлогын зөвлөх Ц.Хулан нар оролцов. Ёслолын эхэнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн туслах Д.Мөнхбадрал “Эх хэлний өдөр зарлах тухай” зарлигийг уншин сонордууллаа.

Төгсгөл нь II нүүрт



ДОТОР НҮҮРТ



БАГШ НАР БАГА ХУРЛААРАА ЦААШДЫН ЗОРИЛТОО ХЭЛЭЛЦЛЭЭ

5




## МЭДЭГДЭЛ

Багануур ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн №19 тоот тогтоол, Гүйцэтгэх захирлын 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/308 тоот тушаалаар жижиг хэрэглэгчдэд борлуулах нүүрсний үнийг дараах байдлаар өөрчилж 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх болсныг мэдэгдэж байна.

| № | Нүүрсний ангилал | Нүүрсний үнэ /1 тонн/ |
|---|---|---|
| 1 | Технологи дамжлагын нүүрс | 36800 |
| 2 | Агуулахаар /цэгээр/ борлуулах нүүрс | 35500 |
| 3 | Шигшиж ангилан ялгасан чанарын нүүрс | 42000 |

| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2425.00 | 2442.00 | ФУНТ | 3096.00 | 3177.00 |
| ЕВРО | 2931.00 | 2939.00 | РУБЛЬ | 40.40 | 42.40 |
| ИЕН | 21.92 | 22.38 | ЮАНЬ | 366.50 | 370.50 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2425.00 | 2438.00 | ФУНТ | 3113.00 | 3173.00 |
| ЕВРО | 2885.00 | 2939.00 | РУБЛЬ | 40.55 | 42.18 |
| ИЕН | 21.91 | 22.39 | ЮАНЬ | 366.00 | 370.00 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР



## Ерөнхийлөгч Х.Баттулга Дорны эдийн засгийн чуулга уулзалтад оролцоно

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга энэ өдрүүдэд Унгар улсын нийслэл Будапешт хотноо ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монголын жүдо бөхийн холбооны Ерөнхийлөгчийн хувиар тус улсад болж байгаа ДАШТ-д баг хамт олноо дэмжихээр хүрэлцэн очоод байгаа юм. Ерөнхийлөгч тус хотод ажиллах үеэрээ ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин болон Унгар улсын Ерөнхий сайд В.Орбан нартай уулзалт хийлээ. Түүнчлэн Жүдогийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний дараа буюу есдүгээр сарын 4-7-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын Владивосток хотод болох Дорны эдийн засгийн чуулга уулзалтад оролцож, хэд хэдэн орны төр, засгийн тэргүүнүүдтэй ажил хэргийн уулзалтуудыг хийх юм.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ




## ЕСДҮГЭЭР САРЫН 01-НД "ЭХ ХЭЛНИЙ ӨДӨР"-ИЙГ ТЭМДЭГЛЭНЭ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Үг зарлигт "Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болсон язгуур соёл, өв уламжлал, төрт ёсны түүхээ дээдлэн хамгаалж, төрийн албан бичиг баримтыг хуульд нийцүүлэн хөтлөх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр эх хэл, түүх соёлоо сурталчлах, иргэн бүр төрөлх монгол эх хэлээрээ зөв ярьж, зөв бичих бүх ард түмний хөдөлгөөн өрнүүлэх зорилгоор, жил бүрийн есдүгээр сарын 01-ний өдрийг "Эх хэлний өдөр" болгон зарласугай.

Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, бүх шатны сургалтын байгууллагууд "Эх хэлний өдөр"-ийг жил бүрийн энэ өдөр уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

**"Эх хэлний өдөр"-ийг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд:**

-Бүх нийтээр монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх, төрийн болон захиргааны албан бичиг хэрэг хөтлөлтийг монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээнд нийцүүлэх, монгол хэл бичиг, кирил үсгийн дүрмээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар санаачилга гарган ажиллах;

-"Эх хэлний өдөр"-ийг угтаж, олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудэххэлээсурталчлах, түүгээр бахархах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн эх хэл соёл, түүх, зан заншил, өв уламжлалын тухай мэдээ мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлгийг орон даяар нэвтрүүлэхийг хэвшүүлж ажиллахыг уриалсугай.

Монгол Улсын их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд жил бүрийн "Эх хэлний өдөр"-ийн хичээлийн нэгдүгээр цагийг монгол хэл, монгол уран зохиол, Монголын түүхийн хичээлийн сэдэв агуулгад багтаан явуулахыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгасугай" гэжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд зарлиг гардуулж хэлсэн үгэндээ "Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээс хойш ард түмэндээ хандсан, бүх нийтийг уриалсан анхны зарлигаа гаргасан нь Эх хэлний өдөртэй болох тухай 2017 оны наймдугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар зарлиг юм. Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, эх хэл, соёлын бүрэн бүтэн, нэгдмэл байдлын баталгаа болсон төрөлх монгол эх хэлээ сахин хамгаалж, хадгалан хөгжүүлэх чиг үүрэг бүхий төр, төрийн захиргаа, судалгаа шинжилгээ болон боловсролын үйлчилгээний байгууллагуудын төлөөлөл та бүхэнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг танилцууллаа. "Чихний чимэг болсон аялгуу сайхан монгол хэл, чин зоригт өвөг дээдсийн маань өв их эрдэнэ" хэмээн хэлэлцдэг төрөлх монгол эх хэл маань даяаршлын эрин үед танигдахын аргагүй болтлоо хувьсан өөрчлөгдөж байна. Зуунаас зууныг дамжин шинэ үгсийн сангаар шинэчлэгдэн баяждаг эх хэл маань эрдэнэ мэт үнэт зүйлсээ хадгалан авч үлдээд, хуучирч улирсныг нь эрэг рүүгээ хаялан гаргаж, ямагт ариудаж байдаг Сүн далай мэт билээ. Орчин цагийн эх хэлний эзэд болсон та бид гадаад хэлийг эзэмшиж, XXI зууны соёлын түрэлт, түрэмгийлэлд автахын хэрээр монгол хэлнийхээ унаган төрхийг алдагдуулсаар байгаа. Эх хэлний хэрэглээний цар хүрээ хумигдаж, хэвлэл мэдээллийн орчны монгол хэлээр харилцаж, энэ нь монгол хэлний үгийн сангийн бүрэн төлөөлөл мэт болжээ. Хэл үгүй бол үндэстэн мөхдөг хүн төрөлхтний гашуун сургамж байна. Хэл, хэлээ дагасан сэтгэхүй,сэтгэлгээгхөгжүүлж,улс орныхоо нэгдмэл байдлыг хангах нь монгол төрийн бодлогын үндэс, суурь юм. Монгол хэл бүтэн байж Монголын ард түмэн, Монгол төр энх оршино. Баян тансаг эх хэлээ дээдэлж, суралцаж, сурталчлан дэлгэрүүлж, ард иргэд нийтээрээ зөв ярьж, зөв бичдэг болохыг уриалсан Ерөнхийлөгчийн зарлигийг олон нийт сайшаан дэмжиж хэрэгжүүлнэ гэж итгэж байна" хэмээгээд зарлигийг гардуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Эх хэлний өдөр зарлах тухай" 25 дугаар зарлигийг БСШУС-ын дэд сайд Ё.Отгонбаяр, нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаа, НЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга О.Эрдэнэжаргал, Шинжлэх ухааны Академийн Хэл, зохиолын хүрээлэнгийн захирал Г.Билгүүдэй, Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Ерөнхийлөгч Б.Галаарид, Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн дэд захирал Г.Гэрэл, ТВ9 телевизийн захирал Т.Баасансүрэн, Монгол Улсын Их Сургуулийн Сургалт, оюутан хариуцсан дэд захирал Б.Очирхуяг, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн сургууль-ийн захирал Ж.Батбаатар, Хэл, иргэншлийн дээд сургуулийн захирал Л.Соёмбо, Үйлдвэрлэл урлалын политехникийн коллеж-ийн захирал Б.Даваажав, Шинэ Монгол бүрэн дунд сургуулийн захирал Ж.Галбадрах, Нийслэлийн 23 дугаар сургуулийн захирал н.Ганболд, Баянзүрх дүүргийн 32 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Л.Алтанцэцэг нар гардан авлаа.

МЭДЭЭЛЭЛ

## ХХААХҮ-ИЙН САЙДЫН НЭРЭМЖИТ ГРАНТАД ШАЛГАРСАН БҮТЭЭЛҮҮДИЙН НЭРС ТОДРОВ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-36 дугаар тушаалаар баталсан "Салбарын судалгаа, хөгжлийн ажилд грант олгох" журмын дагуу хүлээн авсан бүтээлүүдийн нэрс тодорлоо. Тодруулбал, грант горилж мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн эдийн засаг, техникийн чиглэлийн нийт есөн бүтээлийг ирүүлжээ. Бүтээлүүдийг шинжлэх ухааны багтаамж буюу технологийн төвшин, техник эдийн засгийн үзүүлэлт, зах зээлийн эргэлтэд орох чадамжийн түвшин буюу үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ашиглах бодит боломж, ижил төстэй технологи, бүтээгдэхүүн үйлчилгээнээс давуу тал, өрсөлдөх чадвар, нэмүү өртөг бий болгож буй түвшин зэрэг шалгуур үзүүлэлтийг хангасан байдлаар нь үнэлгээ өгөн шалгаруулж грант олгохоор шийдвэрлэсэн байна. Үүнд, ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн Газар тариалан ургамал хамгааллын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D) О.Отгонцэцэг удирдагчтай "Таримлыг ургуулах зохиомол орчны судалгаа", ХААИС-ийн Инженер технологийн сургуулийн багш, доктор (Ph.D) Д.Баатархүү удирдагчтай "Нарны зайгаар ажиллах худгийн насосны ажиллагааг автоматжуулах", ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн Механик мехатроникийн салбарын дэд профессор, доктор (Ph.D) Я.Рэнчинванжил удирдагчтай "Хүндийн хүчний өдөөгчийн үйлчлэлийг судлан, хэрэглээнд нэвтрүүлэх туршилт судалгаа, хөгжүүлэлт" сэдэвт бүтээл тус тус шалгарчээ.

## П.Дамдин: Энэ шагнал намайг биш салбарыг минь үнэлсэн шагнал юм




ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн Монгол Улсын Аж үйлдвэрийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Хөнгөн, хүнсний үйлдвэрийн яамны сайд асан П.Дамдинг хүлээн авч уулзан, хүндэтгэл үзүүллээ. Уулзалтын эхэнд ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цолоор шагнуулсанд баяр хүргэхийн ялдамд үргэлж өөрийн үнэтэй туршлагаасаа салбарынхандаа хуваалцаж, зөвлөж байхыг хүсэв. Мөн салбар яамны хийж хэрэгжүүлж буй ажил, цаашдын зорилтын талаар товч мэдээлэл өгсөн юм. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар П.Дамдин "Энэ шагнал намайг биш салбарыг минь үнэлсэн шагнал юм. Хүнс хөнгөн үйлдвэрийн салбарт 30 жил ажиллалаа. 1960-1968 онд Аж үйлдвэрийн яамны сайдаар ажиллаж байсан. Тухайн үед хүнд, хөнгөн болон хүнсний салбарын бүх үйлдвэр АҮЯ-нд харьяалагддаг байв. Улмаар 1961 онд МАХН-ын XIV их хурлаас шийдвэр гарснаар шинэ уурхай, дулааны цахилгаан станцууд, өндөр хүчдэлийн шугам сүлжээг барьж байгуулан, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх болсон байна. Үүний үр дүнд ТЭЦ2, ТЭЦ3, ТЭЦ4 болон Дархан, Чойбалсан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцууд болон Шарын гол, Багануур, Адуунчулууны нүүрсний уурхайнуудыг шинээр барьж чадсан" гэв.

## "Уул уурхайн нөхөн сэргээлтийн технологи, сургалтын төв"-ийн барилгын шав тавих ёслол боллоо

БОАЖЯ, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг /КОЙКА/, Уул уурхайн нөхөн сэргээлтийн корпорацийн хамтран "Монгол Улсад уул уурхайн байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн чадавхийг бэхжүүлэх" төслийг хэрэгжүүлж байгаа билээ. Улмаар дээрх төслийн хүрээнд "Уулуурхайннөхөнсэргээлтийн технологи, сургалтын төв"-ийг байгуулахаар болсон юм. Тэгвэл уг төвийн барилгын шав тавих ёслол өчигдөр Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн зүүн талд буюу барилга баригдах газарт боллоо. Шав тавих ёслолд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж, БОАЖ-ын дэд сайд Ц.Батбаяр, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Х.Батжаргал болон бусад газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, МХЕГ, УУХҮЯ, Ашигт малтмал, газрын тосны газрын нэр бүхий албан тушаалтнууд оролцсон юм. Харин Солонгосын талаас БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд У Сун болон БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг /КОЙКА/, Уул уурхайн нөхөн сэргээлтийн корпорацийн холбогдох албан тушаалтнууд оролцлоо.

Энэ үеэр БОАЖ-ын дэд сайд Ц.Батбаяр Монгол Улсын уул уурхайн салбарын өнөөгийн байдлыг товч танилцуулснаас гадна уг сургалтын төв бий болсноор уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, туршлага солилцох сургалтад байгаль хамгаалагчид болон бусад мэргэжилтнүүд хамрагдах боломжтой болсныг тэмдэглэлээ. Мөн салбарын менежментийн чадавхийг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байгаагаа онцолсон юм. Элчин сайд У Сун мөн байгаль орчны салбарт хийж буй хамтын ажиллагаагаа улам өргөжүүлж, харилцан бие биенээ дэмжиж ажиллахыг хүслээ. Мөн уг төв үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах мастер төлөвлөгөө боловсруулах, нөхөн сэргээлтийн чиглэлээр сургалт, судалгааны төв байгуулах, жишиг нөхөн сэргээлтийн нарийвчилсан судалгаа болон зураг төсөл боловсруулах зэрэг олон талын боломж нээгдэх аж. Дашрамд дурьдахад, төслийг хамтран хэрэгжүүлж буй Солонгосын Уул уурхайн нөхөн сэргээлтийн корпораци нь тус улсын цорын ганц уул уурхайн сөрөг нөлөөллийн менежментийн мэргэжлийнбайгууллагабөгөөд уул уурхайн олборлолтоос үүдэн сөрөг нөлөөлөлд өртсөн газрыг нөхөн сэргээх зорилго бүхий засгийн газрын агентлаг юм.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

*19 дэх жилдээ*

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

*Улсын бүртгэлийн дугаар: 907300528*
*Индекс: 100757*

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

ЭМГЭНЭЛ

Монгол Улсын Эрүүлийг Хамгаалахын Гавьяат Ажилтан, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүлийг Хамгаалах Яамны Сайд асан (1973-1986) Дарьсүрэнгийн Ням-Осор 2017 оны 8-р сарын 29-нд таалал төгсч гэр бүл, үр хүүхэд, анд нөхдөд нь хүнд гарз тохиолоо.

Дарьсүрэнгийн Ням-Осор нь Монгол оронд эрүүлийг хамгаалах салбар, анагаах ухааныг хөгжүүлэхэд ажил, амьдралаа зориулсан Монголын алтан үеийн төлөөлөгч юм. Тэрээр, Монголын анхны мэргэжлийн эм зүйч, эмийн салбарын зохион байгуулагчийн хувьд үндэсний эм зүйн алба, эм хангамжийн тогтолцоо, эмийн үйлдвэрлэлийг үүсгэн байгуулж, тулгын чулууг нь өрөлцөж, эм зүйн боловсон хүчнийг өндийлгөсөн нэгэн байв. Түүнчлэн Эрүүлийг хамгаалах салбарыг материаллаг баазыг бэхжүүлэх, нийслэл, орон нутгийг орчин цагийн эмнэлэгтэй болгох, эрүүл мэндийн боловсон хүчнийг бэлтгэх, дахин бэлтгэх, салбарын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, гадаад харилцааг хөгжүүлэхийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэсэн өндөр боловсролтой сэхээтэн байв. Талийгаачийн гэр бүл, анд нөхөд болон Ардчилсан намаас төрөн гарсан шилдэг лидер эмэгтэйчүүдийн нэг болох охин Ням-Осорын Туяад Ардчилсан намын удирдлагууд болон нийт гишүүд дэмжигчдийн зүгээс гүнээ эмгэнэл илэрхийлж байна. Ум сайн амгалан болох болтугай.



**ДАРЬСҮРЭНГИЙН НЯМ-ОСОР (1928-2017)**

**Ардчилсан нам**

## ҮЗЭЛ БОДОЛ

# МАН-ЫН УДИРДЛАГУУД ЗӨВШИЛЦӨЛД ХҮРЭЛГҮЙ “ҮЗЭЛЦЭХЭЭР” ШИЙДЛЭЭ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Бүлгийн хурал дээр болсон нэг сонирхолтой үйл явдал нь УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж Ерөнхий сайдыг огцруулах бичигт гарын үсэг зурсан байв. Ерөнхийдөө мягмар гарагийн орой хоёр тал болчихоод байгаа нөхдүүдийг хоорондоо зөвшилц гэсэн чиглэлийг бүлгээс өгсөн юм билээ. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрыг огцруулахгүй, “шүд” сугалах гэж байна гэсэн таамаг яваад байсан. Харин өчигдөр болсон бүлгийн хурлын үеэр Ө.Энхтүвшин Засгийн газрыг огцруулах бичигт гарын үсэг зурсан мэдээлэл гарсан. Ч.Улаан гишүүн ч нэмэгдсэн. Цаашид ч Засгийг огцруулах талд зогсох гишүүд нэмэгдэх нь гэдэг мэдээлэл гараад байгаа. Дээрээс нь УИХ-ын дарга М.Энхболд өчигдөр ээлжит бус чуулган хуралдуулахаар захирамж гаргачихлаа. Мөн бүлгийхнээ хуралд оролцсон 58 гишүүний 30 нь Засгийн газрыг огцруулах нь зөв гэсэн санал өгсөн талаар эх сурвалж мэдээлсэн. Дээрээс нь өчигдрөөс эхлээд байнгын хороод хуралдаж, асуудлаа шийдэж эхэллээ. Тэгэхээр зөвшилцөл “будаа” болжээ.

> ...60 тэрбумтай холбоотой асуудалд хариуцлага тооцно гэвэл намын даргын нэр яригдана. Тэгээд ч Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор хариуцлага тооцох ч асуудал давхар яригдана. Зөвхөн А.Ганбаатар болоод Ц.Сандуй нарт хариуцлага тооцоод өнгөрч бас болохгүй. Тэгвэл 60 тэрбумын албан тушаалын наймааны асуудлыг хүлээн зөвшөөрсөн болчихно...

Угаасаа зөвшилцөнө гэхээр Шадар сайд У.Хүрэлсүхэд хохиролтой байсан, яаж ч бодсон. Мань эр намынхаа даргын суудлыг авч, МАН дотор өрнөөд байгаа бүхий л болж бүтэхгүй асуудлыг засахын төлөө тэмцэнэ гээд байгаа. Гэтэл зөвшилцөх нэрээр хэдэн сайдын суудал фракцынхандаа авч өгөөд өнгөрвөл ёстой утгагүй хэрэг болох байлгүй дээ. Том зорилгын төлөө зүтгэж байгаа учраас хэдэн хүнд сайдын суудал авч өгөөд зогсоно гэж угаасаа байхгүй шүү дээ. Тэгээд ч түүнтэй шинэ гишүүд гэлтгүй хууччуул ч нэгдээд эхэллээ. Тийм болохоор зөвшилцөх гэх ойлголт угаасаа алга болчихож байгаа юм. Тэд 60 тэрбумын асуудлыг ярина. Цаашлаад амлалтаасаа эргэж буцсан, Шадар сайдыг мөрдсөн асуудал гээд юу эсийг ярьж болох билээ. Засгийн газрыг унагах шалтаг олон байна. Яахав, зөвшилцөх нэрээр асуудлыг дуусгах нэг л шалтгаан байж болох юм. Тэр нь Шадар сайдыг тагнасан гэх ажиллагааг У.Хүрэлсүх өөрөө зохион байгуулсан асуудал. АТГ-аас энэ талаар мэдээлэл хийгээд, олон нийтэд мэдэгдчихсэн. Олон жилийн ял төлөвлөсөн гэх мэдээлэл ч тараагаад байгаа. Хэрвээ эрх барьж байгаа, мэдэлтэй тал нь Шадар сайдын энэ асуудлыг барьц болгоод, тохиролцоонд хүрэх гэж хичээж байж болох юм.

Үүнээс өөрөөр зөвшилцөх вариант байхгүй. Ерөнхий сайд болоод, МАН-ын дарга, тэдний талынхан бол ацан шалаанд орчихсон. Нөгөө талын хүссэнээр 60 тэрбумтай холбоотой асуудалд хариуцлага тооцно гэвэл намын даргын нэр яригдана. Тэгээд ч Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор хариуцлага тооцох ч асуудал давхар яригдана. Зөвхөн А.Ганбаатар болоод Ц.Сандуй нарт хариуцлага тооцоод өнгөрч бас болохгүй. Тэгвэл 60 тэрбумын албан тушаалын наймааны асуудлыг хүлээн зөвшөөрсөн болчихно. Цаашлаад өөр олон асуудал босож ирнэ шүү дээ. Тэгэхээр эхнээсээ л эвлүүлэг гэж гүрийснээрээ гүрийхээс өөр ямар ч сонголт алга. За тэр Шадар сайдыг тагнаж, чагнасан гэдэг дээр Ерөнхий сайд аль хэдийнэ өөрөөсөө холдуулсан. Хууль, хүчний байгууллага хүртэл оролцчихлоо. Тийм болохоор МАН-ын томчууд хоорондоо зөвшилцөнө гэсэн ойлголт угаасаа байхгүй. Тэгээд ч яг одоогоор МАН-д “туг тахих” хүн алга. Хэнд хариуцлага тооцох билээ дээ. Одоо зөвхөн хоёр тал “тулах” л үлдлээ. Өчигдөр “тулаан” эхнээсээ өрнөчихсөн. Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал болж, Засгийн газрыг огцруулах асуудлыг хэлэлцлээ. Улмаар байнгын хорооны гишүүдийн олонх нь Засгийн газрыг огцруулахгүй талд санал өгчихлөө. Тодруулбал, Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралд 17 хүн гишүүн оролцож, ес нь огцруулахыг дэмжсэнгүй. Ердөө нэг л хүний санал дутсан гэсэн үг.

Гэхдээ ингээд бүх зүйл дуусаагүй. Ээлжит бус чуулганыг ирэх сарын 7-ны дотор хуралдуулахаар зарлачихсан. Тэгэхээр цаад тал нь ирэх долоо хоногийн лхагва гарагт хуралдаж таарах байх. Ээлжит бус чуулганаар Төрийн байгуулалтын байнгын хороогоор Засгийн газрыг огцруулахгүй гэснийг дэмжих үү гэсэн санал хураалт явуулна. Дэмжихгүй гээд олонх нь өргөчихвөл Засгийн газар огцрох магадлал ихсэнэ. Тэгэхээр долоо хоногийн хугацаанд хоёр тал хэрхэн ажиллаж, гишүүдээ өөрийнхөө талд оруулахаас л Засгийн газрын хувь заяа хамаарах гээд байна. АН-ын бүлэг бол огцруулах талд нь орно. МАХН-ын төлөөлөл болоод бие даагч гишүүн угаасаа огцруулах талд нь зогсох нь ойлгомжтой. Тэгэхээр МАН-ын 65 л хоёр хуваагдахдаа аль нь олонх болсноос асуудал эцэслэн шийдэгдэх болчихлоо. Засгийн газрыг огцруулах талд бол МАН-ын 30 гаруй гишүүн зогсч байна. Гэхдээ өчигдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал бас нэгийг өгүүлчихлээ. Хоёр тал илүү их “алалцах” хэрэгтэй болох нь дээ.

Дугаарын **60** мөр

# Намрын синдром

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Бүр нэг ч биш хэдэн хэдэн шинжээр хавсарсан өвчтэй байгаагийн нэг нь өнөөх сургууль, цэцэрлэгийн асуудал юм. Их, дээд сургууль нь болохоор төлбөрөө хийх чадвартай буюу аав ээж нь мөнгөтэй л байвал ямар ч хамаагүй хүүхдүүдийг алгаа тосоод л авна. Сурлагатай байсан уу, сонирхсон мэргэжлээрээ суралцах чадвартай юу, байгалиас өгөгдсөн авьяас нь ямар юм бэ гэдэг нь огтхон ч хамаагүй. Хүүхэд ирж л байвал элсүүлдэг гаж тогтолцоотой. Эцэст нь баахан А, В үнэлгээтэй чанаргүй мэргэжилтнүүдээр Монголын хөдөлмөрийн зах зээл хахаж байна. Тэгсэн хэр нь сургуулийн өмнөх боловсролын байгууллага, бага сургуулийн хүрэлцээ хангамж нь үнэхээр муу. Азын сугалаагаар цэцэрлэгийн хаяа, арын хаалгаар аятайхан сургуулийн бараа харна. Тэгээд бөөн зардал чирэгдэл, хэл ам болж байж арай гэж бүртгүүлсэн сургууль, цэцэрлэгийн хичээл нь хугацаандаа эхлэхгүй. Тийм ч засвар дуусаагүй, иймч сандал ширээгүй гэсээр байгаад зарим нь 10, 11 дүгээр сард үүдээ нээх нь бий. Зарим нь өөрийн гэсэн байргүй хэдэн жилийн турш сургууль, сургууль дээр очиж гурван ээлжээр хичээллэж, олон дээр олон болж, ад үзэгддэг.

УИХ-ын гишүүд тэрбум, тэрбумаар нь эргээд үлдэх юу ч үгүй, ямар ч үр ашиггүй ажлуудыг бишгүй дээ л нэг санхүүжүүлдэг юм билээ. Уг нь энэ мөнгөөрөө тойрог тойрогтоо жилдээ ганц, хоёроор нь цэцэрлэг, сургууль бариулбал ирээдүй үеийнхээ өмнө байгуулж буй энх цагийн гавьяа гэж хэлэхээр нөхцөл байдал Монголд үүсээд байгааг мэдэхийн цаагуур мэдэж байгаа. Хачирхалтай нь яагаад хийе гэж хичээдэггүй юм бол. Шалтгаан нь тодорхой. Цэцэрлэгийн жаалууд сонгуульд саналаа өгдөггүй учраас тэдэнд хэрэггүй хүмүүс. Харин аав ээж, өвөө эмээг нь аяга цайны сүү, арав, таван цаасаар хуурахад л хангалттай. Сургууль, цэцэрлэгийн барилга бариулснаас хямд төсөр гэдэг тооцоог тэд битүүхэн хийчихээд энэ аргыг сонгодог юм. Харин өөрсдийнх нь хүүхдүүд төрийн зардлаар буюу Засгийн газрын тэтгэлэгээр гадаад, дотоодын нэр хүндтэй сургуулиудад сурах эрх нь нээлттэй. Ард түмэн төрийн албанд байгаа нөхдийг үр ачтай нь албан татвар болон албан бус татаасаар тэжээж тэтгэж ирлээ. Юманд хэмжээ хязгаар бий. Одоо болно. Боль.

Нийгмээ соён гэгээрүүлэх үүрэгтэй, хамгийн цэвэр ариун байх ёстой салбарын нэг нь боловсролын салбар буюу хүүхэд залуусыг хүмүүжүүлж, хөгжүүлж буй тэр талбар. Даанч энэ салбар одоо идээ бээр, хатиг буглаандаа баригдаж гүйцжээ. Нэгэнт энэ өвчин нь даамжирч хүндэрсэн учраас нийгмээрээ эсэргүүцэж, уурлаж бухимдцгааж байна. Өөрөөр хэлбэл, тэсэхийн аргагүй өвдөж эхэлжээ гэсэн үг. Харин үүнийг эмчлэх ёстой эмч буюу бодлогоор зохицуулдаг төр, Засгийн газар нь өөрөө ч бас “өвдчихсөн”, юун ажил үүрэг гүйцэтгэх вэ л гэж байна хөөрхий.

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЗАРЛАЛ

**Огноо:** 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдөр

1. “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн Сэлбэ, Баянхошуу дэд төв төслийн хэрэгжүүлэх явцад байгаль орчны хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn болон www.ub-procurement.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын жагсаалтын 58.1.2-ын 1-д тусгасан “Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр-1”-ийн зээлийн эргэн төлөлт, Улаанбаатар хотын хариуцах хөрөнгө”-өөс гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх ажил болно.

Зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14–16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох баримт бичгийн баталгаажуулсан хуулбарыг хавсарган ирүүлнэ. Үүнд:

2.1 Байгууллагын ерөнхий танилцуулга, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн хуулбар
2.3 Ижил төстэй ажлын туршлагын талаарх мэдээлэл
2.4 Зөвлөх хуулийн этгээдийн ажиллах боловсон хүчний чадавхийн талаарх мэдээлэл /голлох инженер техникийн ажилчдын ур чадварын мэдээлэл, туршлага/
2.5 Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхийн мэдээлэл /2015, 2016 оны санхүүгийн тайлан
2.6 Татварын байгууллагын тодорхойлолт /“ТБОНӨХБАУХАТ хуулийн 14.1.2-т заасны дагуу Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй бол эрх бүхий бус гэж үзнэ”/

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ. Ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийг хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ 2017 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр ирүүлнэ.

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 давхарт Утас: 75757810,**

**Цахим хаяг: www.ub-procurement.mn, www.tender.gov.mn**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** 47 дугаар сургуулийн барилга, сантехникийн засвар /Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо/-ын ажил
**Тендер шалгаруулалтын дугаар:** НХААГ-17/0138

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос 47 дугаар сургуулийн барилга, сантехникийн засвар /Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо/-ын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50,000 /Тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**
**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын дундаж орлого санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх;
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн саналын 30 хувиас багагүй байна;
**Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 он;
Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2015, 2016 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй тусгай зөвшөөрлийн хүрээнд ажил хийж гүйцэтгэсэн байх;

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх:**
- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт,
- 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

Тендерийн хамт 900,000 /есөн зуун мянга/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн, 10 цаг 30 минутад нээнэ.

**Гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх: Оролцох эрхгүй**
**Дотоодын давуу эрхийн зөрүү тооцох эсэх: Тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар**
**Холбоо барих утасны дугаар: 75757807**
**Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn**



# ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ

С.БАТ-ЭРДЭНЭ: "ЦЭРГИЙН АЛДРЫН ХӨШӨӨ"-Г ТҮШИГЛЭН ОХУ-ЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ДАЙЧДАД ЗОРИУЛСАН ДУРСГАЛЫН ЦОГЦОЛБОР, БҮСИЙН ХЭМЖЭЭНИЙ СУРГАЛТЫН ТӨВ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГОЛ ЦЭГ БОЛГОХ БҮРЭН БОЛОМЖТОЙ

VIII нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## БАГШ НАР БАГА ХУРЛААРАА ЦААШДЫН ЗОРИЛТОО ХЭЛЭЛЦЛЭЭ



Э.ТУУЛ

*Боловсролын салбарын 2017-2018 оны хичээлийн жилийн зорилго, зорилтыг тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, зарим дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжиж эхэлсэн хуулиудыг сурталчлан таниулах зорилгоор "Багш нарын бага хурал"-ыг улс орон даяар зохион байгуулсан билээ. Тэгвэл Говьсүмбэр аймгийн "Багш нарын бага хурал" энэ сарын 29, 30-ны өдрүүдэд амжилттай болж, өндөрлөлөө. Бага хурлын нээлтэд аймгийн Засаг дарга Г.Батсуурь, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Уранцэцэг, Сүмбэр сумын Засаг дарга П.Амарсайхан, Боловсрол, соёл урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Мөнхзул болон ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургууль, цэцэрлэгийн багш нар оролцсон юм. Хурлын эхэнд аймгийн Засаг дарга Г.Батсуурь бага хурлын оролцогчдод хандан үг хэлж, мэндчилгээ дэвшүүлж, амжилт хүслээ.*




### Г.Батсуурь: Хичээлийн шинэ жилийн эхнээс багш бүр сургалтын чанарыг сайжруулахын тулд идэвх санаачилгатай ажиллахыг хүсье

*/Говьсүмбэр аймгийн Засаг дарга/*

Тэрбээр "Аль ч улс оронд боловсрол тэргүүлэх салбар нь байдаг. Боловсролын салбарыг хөгжүүлэн урагшуулах гол эх үндэс нь багш юм. Иймээс багшийг хөгжүүлэх, дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын талаар олон асуудлыг тусган "Боловсролыг дэмжих дэд хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж байгаа нь цаашид ажиллах эрч хүч, урам зоригийг өгч байгаа хөшүүрэг, дэмжлэг туслалцаа болж, Засаг дарга миний хувьд ч боловсролыг тэргүүлэх салбарт тавьж, анхаарлаа хандуулан дэмжиж байдгийг хэлэхэд таатай байна. Суралцагчдад чанартай боловсролын үйлчилгээг үзүүлж, боловсролын тогтвортой хөгжлийг хангах нь багшийн чадвараас шууд хамаардаг. Багшийн хөгжил нь боловсролын салбарын өөрчлөлт шинэчлэлийн үндэс болдог. "Боловсролын чанарын шинэчлэл" төслийн хүрээнд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжсэнээр багш бүр сайн зөвлөгөө, сайн туршлагаа түгээн дэлгэрүүлж, сурагч бүрийн сурах идэвх оролцоо нэмэгдэж, багш, сурагчид маань улс, бүс, аймгийн чанартай олимпиад, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон сайн амжилтууд олон бий. Түүнчлэн амжилттай суралцсан 13 суралцагч МУИС-д онлайнаар, Тайваны Коонсен Техникийн их сургуульд хоёр суралцагч урилгаар, гурван сурагч гадаадад тэтгэлгээр суралцахаар болсон гэх мэтчилэн дурьдах зүйл олон байна. Мөн хувийн хэвшлийн боловсролын байгууллагыг бодлогоор дэмжин шинээр байгуулагдсан нэг цэцэрлэгт тусгай зөвшөөрөл олгож, хоёр цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг сунгалаа. Хүүхэд багачуудынхаа хөгжих боломжийг нээж "Буян" цэцэрлэгийн хүүхэд багачуудын урлагийн тоглолтыг Хүүхдийн ордонд хийхэд нь дэмжлэг үзүүлж ажилласан. Боржигин өв соёлыг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд боржигин чуулгын багш нар боржигин морин хуурын сургалтыг хичээллүүлж, хүүхэд багачуудыг сургаснаар, морин хуураар суралцах хүүхдийн тоо нэмэгдэж байна. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд мэргэжил боловсрол, мэдлэг ур чадвараа зориулж байгаа та бүхний хичээл зүтгэлийг урамшуулан дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах нь миний үүрэг хэмээн ойлгож байдаг. Тийм ч учраас аймгийн удирдлагын зүгээс сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч Сүмбэр сумын II сургуулийн 640 хүүхдийн шинэ барилгын зураг, төсвийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар хийлгүүлж, барилгын ажлыг концессын гэрээгээр хэрэгжүүлэх, БСШУС-ын сайдын багцаас Баянтал сумын IV сургуулийн спорт заалны засварын ажил, Баянтал сумын Соёлын төвийн дээврийн засварын ажил, Шивээговь сумын III сургуулийн дээврийн ажил, Сүмбэр сумын II цэцэрлэгийн барилгын гадна дотор цахилгааны монтаж засварын ажлууд гүйцэтгэлийн шатандаа байна. Япон улсын "Өвсний үндэс" төслийн хөтөлбөрөөс Сүмбэр сумын V сургуулийн дотуур байрны өрөө болон гадны талын пасад, тохижилт, I цэцэрлэгийн хуучин барилгад засварын ажлыг хийж гүйцэтгээд байна. Ингэснээр сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамж нэмэгдэж, үүнийг дагаад багш та бүхний ажлын ачаалал багасч хүүхдийн сурч хөгжих орчин нөхцөл сайжирна" хэмээсэн юм. Мөн энэ үеэр алдаа оноогоо дэнслэн, сайтар хэлэлцэх ёстойг сануулаад "2017 оны ЭЕШ-ын хуваарь сонголт явагдаж, нийт 269 элсэгч батламж авч, мэргэжил сонголт хийсэн. Монголын их дээд сургуулийн консерциумаас 130 элсэгч хуваарь сонгосон. 2017 оны ЭЕШ-д аймгийн үзүүлэлтээр 20 дугаар байр, аймаг дүүргийн үзүүлэлтээр 28 дугаар байранд орж, хамгийн бага оноог авсан нь БСУГ-ын суурь бүрэн дунд хариуцсан мэргэжилтний зөвлөмж дутмаг, цөөн төгсөгчтэйгөөс сурагчдын хичээл сонголт оновчтой бус, төгсөх ангийн багшийн арга зүйгээс ихээхэн шалтгаалсан байна.

**Үргэлжлэл нь VI нүүрт**

МЭДЭЭЛЭЛ

## Засаг даргын нэрэмжит "Сургалтын тэтгэлэг"-ийг гардуулав



Аймгийн Засаг даргын нэрэмжит "Оюутны сургалтын тэтгэлэг" авах иргэдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж, тэтгэлэг авах болзол хангасан иргэдийг сонгон шалгарууллаа. Энэ онд нийт 45 иргэн материалаа бүрдүүлж ирүүлснээс 2017 онд ЕБС төгсөөд их, дээд сургуульд элсэн орсон 33 хүүхэд, хоёр болон түүнээс дээш ангийн 12 оюутан байлаа. Журамд заасан болзлын дагуу хагас болон бүтэн өнчин, амьжиргааны орлого багатай, сурлагын голч дүнг үзүүлэлт болгон хэлэлцлээ. 2017 онд аймгийн Засаг даргын нэрэмжит "Оюутны сургалтын тэтгэлэг"-ийг хагас болон бүтэн өнчин 10, ажилгүй, хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон эмэгтэй, амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур орлоготой өрхийн 15, нийт 25 оюутанд тэтгэлэг олгохоор шийдвэрлэлээ. Тэтгэлэгт тэнцсэн иргэдэд аймгийн Засаг даргын "Батламж"-ийг аймгийн Засаг дарга Г.Батсуурь, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Уранцэцэг нар гардууллаа.

ҮЙЛ ЯВДАЛ

## Үндсэн хуулийн өөрчлөлт ард иргэдийн амьдралд шууд нөлөөлдөг учраас анхаарахгүй байхын аргагүй

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ард нийтийн хэлэлцүүлгийг говийн бүсэд зохион байгуулах УИХ-ын Тамгын газраас томилсон ажлын хэсгийн баг Говьсүмбэр аймагт ажиллалаа. Говьсүмбэр аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам, ИТХ-ын Нарийн бичгийн дарга Ж.Оюунбилэг нар оролцож, хэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ "Өмнө нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ард нийтийн саналыг тусгаагүйгээс маргаан их гардаг. Харин энэ удаа УИХ-ын тогтоол гарч, УИХ-ын Тамгын газраас ажлын хэсгийн баг томилон улс орон даяар ард нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж байгаад талархалтай байна. Мөн манай аймагт Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан сумдад ажиллаж байна" гэв.

Хэлэлцүүлгээр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг УИХ-ын Тамгын газрын Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөх Ж.Батсайхан хийж, УИХ-ын үйл ажиллагаатай холбоотой найман, нэмэлт өөрчлөлтийн талаар УИХ-ын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн зөвлөх Д.Мягмарцэрэн, Засгийн газар, засаг захиргааны нэгж, орон нутгийн өөрчлөлтөөр, УИХ-ын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах зөвлөх Н.Мөнхзэсэм, Ерөнхийлөгч, шүүх эрх мэдэл, төрийн албан хаагчийн нэмэлт өөрчлөлтөөр, УИХ-ын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн зөвлөх Л.Батмөнх нар тус тус мэдээлэл танилцуулгыг хийсэн юм.

### Багийн Засаг даргыг шууд томилох нь нам дагасан томилгоо болно

Хэлэлцүүлгийн дараа иргэд санал сэтгэгдлээ хэлж, хуулийн төслийн зарим зүйл заалтыг тодруулж асуув. Баянтал сумын сумын иргэн Л.Лхагвасүрэн "Иргэнийхээ хувьд Үндсэн хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлтийг бүхэлд нь дэмжиж байгаа. Үүнээс Засаг захиргааны нэгжийн тухай өөрчлөлтийг дэмжиж байна.

**Үргэлжлэл нь VII нүүрт**

ОНЦЛОХ МЭДЭЭ

## ИТХ-ЫН ДАРГА Г.БАТЗАМ ИНЧОН ХОТЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Бүгд Найрамдах Солонгос улсад бүртгэлтэй "Ногоон Ази" олон улсын төрийн бус байгууллагын шугамаар Монгол Улсад ажлын айлчлал хийж байгаа Инчон хотын захиргааны Ногоон уур амьсгалын хэлтсийн дарга Чеон Ён Жүн тэргүүтэй Инчон хотын төр захиргаа, олон нийтийн болон судалгааны байгууллагын төлөөлөгчид, БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт, гадаад хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн Х.Майцэцэг нар энэ сарын 27-ны өдөр Говьсүмбэр аймагт зочиллоо. Зочид, төлөөлөгчдийг Говьсүмбэр аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам тэргүүтэй албаныхан нутгийн удирдлагын ордны хурлын танхимд хүлээн авч уулзлаа.

**Үргэлжлэл нь VII нүүрт**

ТҮҮХТ ОЙ

## Эрүүл мэндийн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ой тохиолоо

Э.МӨНХ



Говьсүмбэр аймагт эрүүл мэндийн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ой тохиолоо. Тэртээ 1921 оны наймдугаар сарын 15-нд Их жанжин Д.Сүхбаатарын шийдвэрээр цэрэг, ард иргэдэд үнэ төлбөргүй тусламж үзүүлэх "Өвчтэй хүмүүсийг эмчлэх хороо" байгуулагдсанаар Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн байгууллага үүссэн түүхтэй. Ийнхүү Говьсүмбэр аймагт эрүүл мэндийн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойн баярын хурал дуу бүжгийн "Боржигин" чуулгад ёслол төгөлдөр болж, аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам, аймгийн Засаг даргын орлогч Ш.Билэггүмбэрэл, Сүмбэр сумын ИТХ-ын дарга Т.Түмэнбаяр, засаг дарга П.Амарсайхан, Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнход, аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга С.Ариунгэрэл болон үе үеийн ахмад буурлууд, зочид төлөөлөгчид, ажилтан албан хаагчид оролцсон юм.

**Үргэлжлэл нь VII нүүрт**

## ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# БАГШ НАР БАГА ХУРЛААРАА ЦААШДЫН ЗОРИЛТОО ХЭЛЭЛЦЛЭЭ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь V нүүрт**

Иймд суурь, бүрэн дунд боловсрол хариуцсан мэргэжилтний бодлого зохицуулалтаар хангах, мэргэжлийн арга зүйн зөвлөмж өгөх, аймгийн хэмжээнд багш нарын хамтын ажиллагааг сайжруулах, сонгон судлах хичээлийн аймгийн нэгдсэн хөтөлбөртэй болох зүй ёсны шаардлага байгааданхаарч, хичээлийн шинэ жилийн эхнээс багш бүр сургалтын чанарыг сайжруулахын тулд идэвх санаачилгатай ажиллаж, 2017 онд ЭЕШ-д илүү өндөр үзүүлэлттэй амжилт гаргахыг хүсье. Боловсрол нь хүүхдийн хөгжил, хэрэгцээ сонирхлыг нээлттэй, тасралтгүй, чөлөөт хэлбэрээр, тэгш хангаж чадах тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгддэг. Боловсролын салбарын удирдах ажилтнууд, багш нар маань өөрийгөө хөгжүүлэн, эрхэлсэн ажилдаа эзний ёсоор хандаж, багшийн ёс зүйг чанд баримтлан ажиллах шаардлагатай байна" гэж онцлон тэмдэглээд соён гэгээрүүлэх их үйлсэд нь амжилт хүсч, эрүүл энх байж, эрдэм бэлгийн гэгээн гэрлээ түгээж явахын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлээд 2017-2018 оны хичээлийн жилийн багш нарын бага хуралд амжилт хүслээ.

Багш нарын бага хурал эхний өдөр Боржигин чуулгын их танхимд болж, аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Мөнхзул Боловсролын салбарын 2016-2017 оны хичээлийн жилийн ололт, амжилт, сургамж, дүгнэлт, 2017-2018 оны хичээлийн жилийн зорилтын төслийн талаар мэдээлэл хийлээ. Энэ хичээлийн жилд тус аймагт сургуулийн өмнөх боловсролын 49 бүлэгт 1652, суурь, бүрэн дунд боловсролын 123 бүлэгт 3481 суралцагч сурах бол мэргэжлийн 236 багш ажиллах юм байна. Энэ удаагийн бага хурлаас II сургуулийн нэг байрыг дотуур байр болгох, багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарах, Шивээговь сумын сургуулийн байр их хэцүү байгаа тул шинээр байртай болгоход анхаарах, I сургуулийн спорт заалны асуудлыг шийдвэрлэх, Баянтал сумын Спорт заалыг шинээр барихад анхаарах гэх мэт санал гарсныг аймгийн удирдлагуудад хүргэхээр боллоо. Мөн багшийн ёс зүйн дүрмийн дагуу аймгийн боловсролын салбарын ёс зүйн зөвлөлийн тайланг Сүмбэр сумын I сургуулийн багш Н.Мөнхзул илтгэл тавьж, хоёр жилийн хугацаанд хийсэн ажлаа тайлагнасан юм. Тайланд нийт ирсэн өргөдөл гомдлын дийлэнх хувь нь удирдлага, багш, эцэг эхчүүдийн үл ойлголцлоос үүдэн гарсан хэмээн дурьджээ. Мөн багш, ахлах ангийн сурагчдаас багш нарын талаархи судалгааг авч, дүнг нэгтгэснээ танилцуулсан юм. Судалгаанд ахлах ангийн нийт 200 гаруй сурагч оролцсоноос нийт сурагчдын 64 хувь нь багш нар заах арга барилаа өөрчлөх ёстой гэсэн бол 33 хувь нь ялгаварлан гадуурхах байдал ажиглагддаг гэж хариулжээ. Тиймээс цаашдаа эдгээр асуудалданхаарахшаардлагатай хэмээн сануулсан. Харин багш нараас авсан санал асуулгаар эцэг, эхчүүдтэй үл ойлголцох, Ёс зүйн дүрмээ судлаагүйгээс болж хариуцлага тооцуулах хэмжээнд хүрснээ ухаардаггүй зэрэг хүндрэлүүд гарсан хэмээн Н.Мөнхзул багш илтгэлдээ дурьдаж байлаа. Ийнхүү бага хурал үргэлжилж, тайлангийн дараа дүрмийн дагуу хоёр жилд Ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүдийг Багш нарын бага хурлаараа сонгодог тул нийт долоон хүний бүрэлдэхүүнтэй сонгож, даргаар нь Шивээговь сумын багш Одончимэгийг сонголоо.



*Энэ үеэр Боловсрол, соёл урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Мөнхзултай цөөн хором ярилцлаа.*

### Э.Мөнхзул: Багш, сурагчид болоод эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талын олон ажлыг хийхээр төлөвлөөд байна



**-Юуны өмнө хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе. Өнөөдөр "Багш нарын бага хурал" болж байна. Бага хурлаар ямар асуудлуудыг хэлэлцэж байна вэ?**

-Баярлалаа. Бид энэ удаагийн "Багш нарын бага хурал"-аараа өмнөх оны ажлын тайлангаа хэлэлцэж, хичээлийн жилийн шинэчлэлийн төлөвлөлтөө ярилцлаа. Мөн БСШУСЯ-аас энэ хичээлийн жилд ахлах ангийн сургалтын шинэчилсэн хөтөлбөрөөр хичээллэх, сургалтын арга зүйн тал дээр нэлээд анхаарах, хэрэгжиж буй хуулиуд багшийн ёс зүйн дүрэмтэй хэрхэн нийцэхийг тайлбарлан, таниуллаа. Мөн БСШУСЯ-аас "Багшийн ёс зүй" сэдэвт гурав хоногийн сургалтад манай аймгаас 17 багш үндэсний сургагч багшаар бэлтгэгдэж, аймагтаа ЕБС, СӨБ-ын болон УУПТК-ийн 300 гаруй багшид сургалтыг хоёр өдөр зохион байгууллаа.

**-Өнгөрсөн хугацаанд Говьсүмбэр аймгийн боловсролын салбарт нэлээд их ажлууд хийсэн тухай мэдээллээ. Эндээс онцлох зүйл нь юу вэ?**

-2016-2017 оны хичээлийн жилд бид стандартад суурилсан боловсролын тогтолцоо, сургууль-хүн хөгжлийн төв, эрүүл, аюулгүй, ээлтэй орчин, тэгш хүртээмжтэй үйлчилгээ гэсэн гурван гол зорилтыг дэвшүүлэн ажилласан. Энэ ч үүднээсээ сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулж амьжиргааны баталгаажихтөвшингөөсдоогуур орлоготой өрхийн 60 хүүхэд, малчин өрхийн 80 хүүхдийн сургалтыг төрийн өмчийн цэцэрлэгүүд болон ДЗОУБ-тай хамтран зохион байгууллаа. Бага боловсролд 1740 сурагч суралцсан. Сурагчдыг бүрэн хамруулах зорилгоор сум, багийн удирдлагуудтай хамтран ажилласны үр дүнд хамран сургалт 100 хувьд хүрсэн. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил аргазүйн удирдлагаар хангах, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сайн үйл ажиллагаагаар хамтран сурч хөгжихөд чиглэсэн цэцэрлэгийн багш удирдлагуудад зөвлөн туслах, чадваржуулах, сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий үндэсний зөвлөн туслах багтай хамтран ажилласан. Үүний үр дүнд цэцэрлэг тус бүр хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцын оновчтой сайн болон сайжруулах цаашид анхаарах асуудлаа олж авч чадсанаар сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт сайжирсан. "Боловсролын талаар баримталж буй бодлого", "Тогтвортой хөгжлийн боловсрол", амьдрах ухаанд суурилсан агуулга арга зүйг сургалтын төлөвлөгөө хөтөлбөрт тусгах арга зүйн сургалтыг нийт таван сургууль дээр зохион байгууллаа. Сургалтын үр дүнд Тогтвортой хөгжлийн боловсрол-Багшийн цогц чадамж, Амьдрах ухаанд суурилсан сургалтын модультай танилцаж, сургалтын арга зүйд суралцсан. Түүнчлэн бид багшийн хөгжилдөө анхаарч, залуу багш нарын туршлага солилцох зөвлөгөөн, Японы Нагоя их сургуультай хамтран ажиллах, БСШУСЯ-аас зохион байгуулсан бүсийн сургалтад Тогтвортой хөгжлийн боловсролын хэрэгжилтийн тайланг тавьж, туршлага солилцсон гэх зэргээр тоочоод байвал нэлээд ажлуудыг хийж хэрэгжүүлээд байна. Цаашдаа ч багш, сурагчид болоод эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талын олон ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

**-Бага хурлаас ямар саналууд гарав. Цаашид хийж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудаасаа дурьдахгүй юу?**

-Бага хурлаас сургуулийн дотуур байртай болгох, багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх гэх зэрэг нэлээд олон санал гарсан. Энэ бүхнийг аймгийн удирдлагуудаа танилцуулж, шийдвэрлэх талаас нь хамтран ажиллах болно. Мөн БСШУСЯ-аас дэвшүүлсэн зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх зорилтуудаа тодорхойллоо. Тухайлбал, Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран "Боловсролын салбарт хэнийг ч орхигдуулахгүй байх" төслийн хүрээнд боловсролын салбарын удирдах ажилтан, багш, албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн, ёс зүй, ажлын хариуцлагыг сайжруулна. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилга, байгууламжид судалгаа хийж, гамшгийн эрсдэлийг бууруулах, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ. Сургалтын чанарыг сайжруулах үүднээс сорилго шалгалтыг үе шаттай зохион байгуулан, нэгдсэн төлөвлөгөөтэй болж хэрэгжүүлэх, аймгийн Математикийн хөтөлбөртэй болно, түр сургалтын төвүүдтэй хамтран ажиллана. Хүүхдийн сурч, хөгжих хүсэл эрмэлзлэлийг дэмжихийн зэрэгцээ хүмүүжил, төлөвшилд эерэг нөлөө болохуйц олон талт, үр дүнтэй ажлуудыг зохион байгуулна. СӨБ-ын хүрээнд "Хүүхэд гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ. Бага боловсролынсургалтынчанар, үр өгөөжийг дэмжсэн "Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр", "STEM"-ийн сургалтыг амжилттай хэрэгжүүлж, туршлагаа түгээн дэлгэрүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах орчинг сайжруулах төслийг ХХҮГ-тай хамтран зохион байгуулна. Орон нутгийн боловсрол, соёл, спортын байгууллагын хамтын ажиллагааг дэмжсэн хөтөлбөр, арга хэмжээг өргөжүүлнэ гэсэн зорилтыг дэвшүүлээд байна.

*Харин хоёр дахь өдөр нь багш нарыг сургуулийн өмнөх боловсрол, суурь болон ерөнхий боловсрол хэмээн ангилж, гурван хэсэгт хуваан хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Энэ үеэр сургалтыг удирдан явуулж буй мэргэжилтнүүдийн сэтгэгдлийг сонслоо. Хамгийн түрүүнд I сургуулийн хурлын танхимд болж буй багш нарын сургалт руу орлоо. Сургалтыг аймгийн БСУГ-ын ахлах мэргэжилтэн Ю.Цэвэлмаа удирдан явуулж байсан юм.*

### Ю.Цэвэлмаа: "Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр"-ийг яг гардан хэрэгжүүлэх хүмүүс нь багш нар



*/БСУГ-ын ахлах мэргэжилтэн/*

-Өчигдөр буюу наймдугаар сарын 28-ны өдөр орон нутгийн сургагч 13 багш, мэргэжилтнүүд суурь, бүрэн дунд боловсролын 130 багш, удирдах ажилтнуудад "Багшийн ёс зүй " сэдвээр сургалт явуулсан. Өнөөдөр суурь, бүрэн дунд боловсролын 117 багш маань "Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй" сургалтад хамрагдаж байна. "Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр"-ийг яг гардан хэрэгжүүлэх хүмүүс нь багш нар. Тийм учраас хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх тал дээр бид багш нартайгаа хамтран ажиллана. Энэ сургалтын үр дүнд бид судлагдхуун бүрээр аймгийн нэгдсэн сонгоны судлах хичээлийн хөтөлбөртэй болох зорилт тавиад ажиллаж байна. Энэ хичээлийн шинэ жилд аймгийн төв дээр гурав, суманд хоёр сургууль сурагчдаа хүлээж авах бэлтгэл ажлаа 95 хувьтай хангаад хичээлийн шинэ жилийн нээлтийн хөтөлбөрөө БСУГ-т хүргүүлээд байна.

*Харин БСУГ-ын мэргэжилтэн Б.Болормаагаар ахлуулсан цэцэрлэгийн багш нарын сургалт аймгийн ОБГ-ын хурлын танхимд болж байв. Энэ үеэр БСУГ-ын мэргэжилтэн Б.Болормаагаас зарим зүйлийг тодрууллаа.*

> Боловсрол нь хүүхдийн хөгжил, хэрэгцээ сонирхлыг нээлттэй, тасралтгүй, чөлөөт хэлбэрээр, тэгш хангаж чадах тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгддэг. Боловсролын салбарын удирдах ажилтнууд, багш нар маань өөрийгөө хөгжүүлэн, эрхэлсэн ажилдаа эзний ёсоор хандаж, багшийн ёс зүйг чанд баримтлан ажиллах шаардлагатай байна

### Б.Болормаа: "Багшийн ёс зүй" сургалтыг долоон дэд сэдвийн хүрээнд оролцогчдын оролцоон дээр тулгуурлан зохион байгуулж байна



*/БСУГ-ын мэргэжилтэн/*

-Сургуулийн өмнөх боловсролын удирдах ажилтан, багш, туслах багш нарын төлөөллөөс бүрдсэн нийт 86 хүний бүрэлдэхүүнтэй "Багшийн ёс зүй, харилцаа" сэдэвт сургалтыг зохион байгуулж байна. Сургалтаар ёс зүй, мэргэжлийн ёс зүй, багшийн ёс зүйн үндсэн ойлголтуудыг өгч байна. Багшийн ёс суртахууны хэм хэмжээ, нийгэмд эзлэх байр суурь, нэр төр, олон нийтийн цахим сүлжээн дэх багшийн ёс зүй сэдвийн дор амьдрал дээр гардаг жишээ тохиолдлуудтай холбон ярилцлаа. Мөн "Ёс суртахууны хэм хэмжээ хуулиар зохицуулагдсан нь" буюу Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль зэргийг багшийн ёс зүйн дүрэмтэй нийцүүлэн тайлбарлаж, танилцууллаа.. Үүнээс гадна 2017-2018 оны хичээлийн шинэ жилд манай аймгийн хэмжээнд цэцэрлэгүүд маань хүүхдүүдээ хүлээж авах бэлтгэлээ 90 хувьтай хангаад байна. Аймгийн хэмжээнд бүртгэлийн үйл ажиллагааг энэ сарын 25-нд нэгдсэн журмаар явуулж, элсүүлэх ёстой хүүхдүүдээ бүртгэж, ямар нэгэн байдлаар иргэдийн гомдол бухимдалгүйгээр зохион байгуулсан.

*Түүнчлэн бага боловсролын багш нарын сургалт аймгийн ЗДТГ-ын байранд болж байлаа. Сургалтыг БСУГ-ын мэргэжилтэн С.Энх-Амгалан ахлан явуулж байсан юм.*

### С.Энх–Амгалан: БСШУСЯ–аас зургаан настай хүүхдийн бэлтгэл хөтөлбөрийн 60 цагийн зөвлөмж, сурах бичгийг шинэчлэн боловсруулж гаргасан



*/БСУГ-ын Бага боловсрол, насан туршийн боловсрол хариуцсан мэргэжилтэн/*

-2017-2018 оны хичээлийн жил эхлэхэд хэдхэн хоног үлдсэн байна. Говьсүмбэр аймгийн хувьд энэ сарын 29-нд бага хурлаа эхлүүлсэн. Хичээлийн жилийн шинэчлэлийн төлөвлөлт, өмнөх оны ажлын тайлангаа бага хурлаараа хэлэлцлээ. БСШУСЯ-аас энэ хичээлийн жилд ахлах ангийн сургалтын шинэчилсэн хөтөлбөрөөр хичээллэх, сургалтын арга зүйн тал дээр нэлээд анхаарахыг чиглэл болгосон. Мөн салбарын яамнаас багшийн ёс зүйн сэдвээр үндэсний хэмжээнд сургалт явуулж байгаа. Энэ сургалт ч мөн манай аймагт зохион байгуулагдаж байна. Үүнээс гадна тогтвортой хөгжлийн боловсролын асуудлыг дэлхий нийтээрээ сургалтын процесст оруулах талаар нэлээд яригдаж байна. Сургуулийн өмнөх боловсролын багш нарт тогтвортой хөгжлийн боловсролын талаар сургалт зохион байгууллаа. Бага суурь, ахлах ангийн багш нарт ёсзүйн асуудлаар сургалт зохион байгуулж байна. Энэ оны долдугаар сарын 1-ээс мөрдөгдөж буй Зөрчлийн тухай хууль нь, Боловсролын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулиуд яаж тусч, эрх зүйгээр зохицуулагдаж байна вэ, багш юуг анхаарах вэ гэдгийг сурталчлан таниулахад сургалтын маань зорилго оршиж байна. Өнөөдөр бол ахлах ангийн багш нарт ахлах ангийн сургалтын төлөвлөгөө хөтөлбөр, аргазүйн талаар судлагдахуун бүрээр сургалт хийж байна. Миний хувьд нэгдүгээр анги дааж авч байгаа багш нарт, нэгдүгээр ангийн сурагч, зургаан настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал, сургуульд ороод дасан зохицох, цаашид сургалтын арга зүйг яаж авч явах вэ гэдэг сэдвээр сургалт хийж байна. Энэ сургалтыг жил бүр явуулдаг. Энэ жилийн хувьд БСШУСЯ-аас зургаан настай хүүхдийн бэлтгэл хөтөлбөрийн 60 цагийн зөвлөмж, сурах бичгийг шинэчлэн боловсруулж гаргасан. Бага боловсрол хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулаад, үндэсний хэмжээнд орон даяар сургалтууд хийгдэж байна. Ингээд энэ хичээлийн жилд Говьсүмбэр аймаг таван сургууль, өмчийн буюу төрийн есөн цэцэрлэг сургалтын үйл ажиллагаагаа эхлэх бэлтгэл ажлаа бүрэн хангаад байна.

# ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

## ИТХ-ЫН ДАРГА Г.БАТЗАМ ИНЧОН ХОТЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ





**Үргэлжлэл. Түрүүч нь V нүүрт**

Уулзалтын эхэнд аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам цөлжилтөд нэрвэгдэж доройтсон газрыг нөхөн сэргээх, говийн унаган мод загийг тарьж ургуулах болон ойн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг чадавхижуулахад БНСУ-ын Засгийн газар, төрийн болон ТББ-ын Монгол Улсад хэрэгжүүлж буй "Ногоон хэрэм" төсөл, "Ногоон Ази" сүлжээний болон бусад төсөл хөтөлбөрүүд томоохон үүрэг гүйцэтгэж байгааг онцлон дурьдав. Мөн "Үүнээс зөвхөн "Ногоон Ази" олон улсын төрийн бус байгууллагын шугамаар Монгол оронд 2000 оноос өдийг хүртэл нийт 580 га газарт 580 гаруй мянган мод тариад байгаа бөгөөд Булган аймгийн Баяннуур, Дашинчилэн сум, Дундговь аймгийн Сайнцагаан сум, Төв аймгийн Эрдэнэ сум, Улаанбаатар хот Багануур дүүрэг гэх газруудад цөлжилт, шар шороон шуурганы эсрэг тогтвортой хөгжлийг хангахын тулд жишиг загвар цэцэрлэг байгуулан ажиллаж байгаа тухай мэдээлэл өмнө нь авч байсан" хэмээн хэлсэн юм. Тэрбээр цааш нь орон нутгийнхаа талаар танилцуулав. "Манай аймгийн хувьд 1994 онд бие даан шинээр байгуулагдсан аймаг бөгөөд 17 мянган хүн амтай 5500 га газар нутагтай боловч харьцангуй дэд бүтэц сайн хөгжсөн. Улаанбаатар хотоос 230 км-т оршдог. Төмөр зам, автозамаар БНХАУ болон ОХУ-тай холбогдох боломжтой эрчим хүч болон харилцаа холбооны томоохон зангилаа болсон хөгжих ирээдүйтэй ложистикийн томоохон төв. Говьсүмбэр аймаг маань байгалийн бүс бүслүүрийн хувьд өвөрмөц бөгөөд тал хээрийн бүсийн төгсгөл, говь цөлийн бүсийн эхлэлийн зааг дээр оршдог онцлогтой юм. Дэлхий нийтээр сэтгэл эмзэглэн тэмцэж байгаа уур амьсгалын өөрчлөлт, дулаарлаас үүдэлтэй хур тунадасны хэмжээ багасч, цөлжилт хүрээгээ тэлж байгаа энэхүү үйл явц нь энд илүү тод мэдрэгдэж бүс нутгийн байгалийн бүс бүслүүрт эрс өөрчлөлтийг авчирч гол нуурууд ширгэж, биологийн төрөл зүйлийн өөрчлөлт эргэлт буцалтгүйгээр явагдаж, ургамал, ан амьтны төрөл зүйл улам бүр хомсдож энэ нь уламжлалт мал аж ахуйн салбараар дамжин хүн амын амьжиргаа, аймгийн эдийн засагт ч сөрөг нөлөөлөл үзүүлсээр байгаа нь орон нутгийн удирдлагын анхаарлын төвд байдаг асуудлын нэг яах аргагүй мөн юм. Орон нутгийн удирдлагын зүгээс цөлжилтийг хязгаарлах талаар төрөөс баримталж буй бодлого шийдвэрийг орон нутагтаа хэрэгжилтийг ханган олон талтай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байгаагийн заримаас дурьдахад, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авч хэмжээг өргөжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж газар нутгийн 20 орчим хувийг тусгай хамгаалалтад аваад байна. Мөн 2014 оноос ногоон байгууламжийн арчилгааг хариуцан ажиллах таван хүний байнгын орон тоо бүхий Сум дундын ойн ангийг байгуулан санхүүжүүлэн ажиллаж байгаа бөгөөд зуны улиралд орон нутгийн ажилгүй иргэдийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээр дамжуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслөөс цалин хөлсийг нь олгон 2013-2017 онд орон нутгийн ажилгүй 398 иргэнийг түр ажлын байраар ханган ажиллалаа. Сүүлийн жилүүдэд аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Сүмбэр гарден цэцэрлэгт хүрээлэн байгуулахад 413.4 сая төгрөг зарцуулж, 18 га талбайд 28526 мод сөөг тарьж, усжуулалтын ажлыг хамт гүйцэтгэсэн бөгөөд автозамын дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулах ажилд нэлээд анхаарал тавьж, 2014-2017 онд 25 га талбайд 96.3 сая төгрөг зарцуулан 18590 ширхэг мод тарьж байна. Түүнчлэн мод тарих ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар анхаарч жил бүр бүх нийтийг хамарсан ажил хэлбэрээр явуулан иргэд, албан хаагчдыг мод тарих аянд оролцуулан ажиллаж хэвшээд байгаа бөгөөд давхардсан тоогоор 374 ААНБ-ын 9921 иргэн оролцсон дүнтэй байна. Мөн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны VII тогтоолоор "Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам"-ын дагуу аймгийн БХНСАХЗ-аас 37 иргэн, нэг аж ахуйн нэгж, байгууллагын тарьж ургуулсан 3534 модонд 15 887 500 төгрөгийн урамшуулал олгосон. Албан байгууллага, иргэдийн энэ чиглэлд идэвхжүүлэхээр ИТХ-аас энэ жил аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдийн дунд шилдэг тохижилт ногоон байгууламжтай байгууллага, иргэнийг шалгаруулах болзолт уралдаан зарлан ажиллаж байгаа" гэж ярьсан юм.

Энэ үеэр Инчон хотын захиргааны Ногоон уур амьсгалын хэлтсийн дарга Чеон Ён Жүн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэлхий нийтээрээ тогтвортой хөгжлийн замыг сонгож буй энэ цаг үед орон нутагт хийж, бүтээж байгаа ногоон бүтээн байгуулалтын ажлыг сайшаагаад "Дэлхийн дулаарлын улмаас цөлжилт эрчимтэй явагдаж буй өнөө үед Инчон хотын иргэдийн дэмжлэгээр Монгол Улсад Булган аймгийн Баяннуур, Дашинчилэн сумдад "Инчоны мөрөөдлийн төгөл" төслийг 2008 оноос амжилттай хэрэгжүүлж, нийт 67 га талбайг хамарсан 98.3 мянган мод тариад байна. Цаашид шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх чиглэлд манай улстай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, Говьсүмбэр аймагтай хамтран ажиллах тал дээр идэвхийлэн ажиллах болно" гэдгээ илэрхийлжээ. Уулзалтын үеэр талууд харилцан санал солилцож, цөлжилттэй тэмцэх чиглэлд манай аймагт төгөл байгуулах боломж нөхцөлийн талаар тодотгон ярилцсан бөгөөд дараа нь "Сүмбэр гарден" цэцэрлэгт хүрээлэн болон Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газрын үйл ажиллагаатай танилцлаа.

ҮЙЛ ЯВДАЛ




## Үндсэн хуулийн өөрчлөлт ард иргэдийн амьдралд шууд нөлөөлдөг учраас анхаарахгүй байхын аргагүй



**Үргэлжлэл. Түрүүч нь V нүүрт**

Ерөнхий сайд аймгийн Засаг даргыг, аймгийн Засаг дарга нь сумынхаа даргыг, сумын Засаг дарга нь багийн даргаа томилох энэ заалтыг дэмжиж байна. Мөн шүүхийн талаар нэмэлт, өөрчлөлт орж байна. Шүүхийн Ерөнхий зөвлөл нь шүүгчийг томилохдоо УИХ-аар хэлэлцүүлдэг байх нь зөв. Шүүхийн өмнөх тогтолцоо өөр байсан. Аль эрх барьж байгаа нам, засгийн талд шүүх ажиллаж шийдвэр гаргадаг байдал маш их хүчээ аваад байсан" гэж онцоллоо.

Хэлэлцүүлэгт оролцсон иргэд багийн Засаг даргыг шууд томилох нь мөн нам дагасан томилгоо болно. Мөн Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийг хасах нь буруу гэх санал ч хэлж байсан юм. Нөгөө талдаа шүүгчийг УИХ-аар хэлэлцэж батлахыг нэлээд дэмжиж байв.

Харин Шивээговь сумын иргэн Д.Сүхбаатар "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлэлцүүлэгт хоёр дахь удаагаа орж байна. Өнгөрсөн дөрөвдүгээр сарын сүүлд Улаанбаатар хотод зохион байгуулсан хэлэлцүүлэгт мөн оролцсон. Аймаг, орон нутгийг хот болгох заалтыг дэмжиж байгаа. Хувь хүний санал гэвэл УИХ-ын гишүүнийг нэг удаа улируулан сонгодог болмоор байна. Дөрвөн жилийн хугацаанд сонгууль хийсээр байтал ажил хийж амжихгүй байна" гэлээ.

### Сумдыг шууд тасдаад нийлүүлчихнэ гэдэг бол өрөөсгөл ойлголт

Говьсүмбэр аймгийн хувьд гурван сумтай хэдий ч Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Дорноговь аймгийн зарим сумдын иргэд төр захиргааны үйлчилгээг Чойроос авдаг юм байна. Иймээс Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хилийн цэс тогтоох, зарим аймаг, сумдыг нэгтгэх нь зөв гэдэгт цөөнгүй иргэд санал хэлж байлаа. Энэ талаар Сүмбэр сумын иргэн Г.Бумцэрэн "Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар нэлээд хугацаанд ярьж байна. Ард түмэн үүнд ач холбогдол өгч байгаа. Хуулийн өөрчлөлт ард иргэдийн амьдралд шууд нөлөөлдөг учраас анхаарахгүй байхын аргагүй. Тэр дундаа Үндсэн хуульд бол маш нухацтай хандах ёстой. Манай аймаг 1991 онд Чойр хот болж, 1994 онд Говьсүмбэр аймаг болсон. Дархан, Эрдэнэтийг дагаад хотын статустай болсон юм. Говьсүмбэр бол боржигин түмний цөм болсон аймаг. Тиймээс эргэн тойронд байгаа сумдыг Говьсүмбэрт нэгтгэвэл хүн ам олонтой, хөгжих боломжтой хот болж хөгжих боломжтой. Тэр аймгийн сумдыг шууд тасдаад нийлүүлчихнэ гэдэг бол бас өрөөсгөл ойлголт. Гэхдээ харьялал, газар нутаг, төр захиргааны үйлчилгээ авч байгаа байдлаар нь хилийн цэсийг бодож үзмээр байна. Дундговийн наад талын сумдын айлуудын хүүхдүүд Говьсүмбэрт сурч, эмнэлэг, төр захиргааны бүх үйлчилгээг газар нутгийн дөт байдлаар нь эндээс авдаг" гэлээ.

Дээрх хэлэлцүүлэгт Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын орон нутаг, төр захиргааны байгууллагын ажилчин албан хаагч, оршин суугчид оролцов.

ТҮҮХТ ОЙ

## Эрүүл мэндийн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ой тохиолоо

**Үргэлжлэл. Түрүүч нь V нүүрт**

Ёслолын ажиллагааг нээж, Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнх-Од хэлсэн үгэндээ "Говьсүмбэр аймагт эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан эрүүл мэндийн салбарын нийт ажилчдын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлж байгааг минь хүлээн авна уу. Манай аймагт тэртээ 1927 онд анх нэг бага эмч, хоёр сувилагчтайгаар орчин цагийн анагаах ухааны эх суурь тавигдсанаас хойш үргэлж өөдлөн дэвшиж, өргөжин тэлж ирсэн 90 жилийн өндөрлөгт та бид хамтдаа хүрэлцэн ирлээ. Хүн зөвхөн өвдсөн үедээ оточ маарамбад ханддаг байсан цаг үе түүх болон өнгөрч, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг аливаа хүчин зүйлийг судалдаг, тэр бүхнийг арилгахын төлөө тэмцдэг, хүн амын эрүүл мэндийн байдалд судалгаа дүгнэлт өгдөг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлдэг , өвдсөн үед нь өрнө дорны эмийн болон эмийн бус, мэс заслын аргаар эмчилдэг бүхэл бүтэн тогтолцооны нэгээхэн хэсэг болж хөгжиж бид 90 жил болжээ. Өнөөдөр манай аймгийн эрүүл мэндийн салбар төр хувийн хэвшлийн 20 гаруй байгууллагатай, 200 хол давсан эмч, эмнэлгийн ажилтантай эрүүл мэндийн анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээг үзүүлж, сүүлийн есөн жил эхийн эндэгдэлгүй ажиллаж, нялхасын эндэгдэл, халдварт өвчний гаралтыг улс аймгийн дунджаас доогуур төвшинд барьж, хүн амын дундаж наслалтыг 73.4, жирэмсний эрт үеийн хяналтыг 85, заавал хийх дархлаажуулалтыг 99 хувьд хүргэсэн амжилттайгаар түүхэн ойгоо угтаж байна. Эрдэнэт хүний амь нас, эрүүл мэндийн төлөө сэтгэл зүрхээ харамгүй зориулж яваа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нэгэн сэтгэлээр хамтран зүтгэдэг нийт эрүүл мэндийн байгууллагын ажилтан ажиллагсад болон үе үеийн ахмадуудаа ойн баярын мэндийг дахин хүргэхийн ялдамд ард олныхоо эрүүл энхийг сахин хамгаалах ариун шударга үйлсэд нь амжилт хүсье" хэмээсэн юм.

Түүхт 90 жилийн ойгоороо салбартаа үр бүтээлтэй ажилласан үе үеийн ахмад буурлууд, ажилтан албан хаагчдад төр засагтаа хөдөлмөр зүтгэлээ үнэлүүлж, төрийн одон медаль, ЭМЯ-ны шагнал, аймаг, сумын









Засаг даргын жуух, 90 жилийн ойн медалиар шагнагдсаныг гардууллаа. Тодруулбал, "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар Эрүүл мэндийн газрын ахмад ажилтан Жамбажанцангийн Өсөхбаяр, "Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан"-аар С.Уранбилэг, Б.Одончимэг, С.Отгончимэд, Т.Тогтох, Д.Должинсүрэн, Г.Тэрбиш, З.Одончимэг, Б.Ичинхорлоо, Д.Лхагвасүрэн, Ц.Хүрэлбаатар, Д.Отгонбаяр, Ж.Нансалмаа, Н.Энэбиш, Д.Санжидмаа, Д.Наранчимэг, Л.Дэлгэр, Х.Ичинхорлоо, Б.Номин-Эрдэнэ, С.Амаржаргал, Р.Батцэцэг, С.Нямдаваа, М.Марийма, М.Оюунцэцэг, Ц.Таванцэцэг, Д.Дэлгэрмаа, Б.Өнөрцэцэг, Н.Нарантуяа, А.Пүрэвсүрэн, Б.Энхцэцэг, У.Ундраа, С.Сарантогтох, Д.Оюунчимэг, Ч.Түмэнбаяр, Ш.Апъяамаа нарын хүмүүс шагнагдлаа. Харин ЭМЯ-ны "Жуух бичиг"-ээр Л.Алтантуяа, Г.Ганхуяг, А.Оюун-Эрдэнэ, Г.Булганжаргал, Н.Доржсүрэн, Б.Буянжаргал, Д.Баасанжаргал, Ү.Азжаргал, Х.Баярсахайн, Г.Бат-Ирээдүй нар шагнагдсан бол аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр Г.Цэрэндолгор, О.Цэрэнчимэд, Б.Болормаа нар шагнагджээ. Мөн "90 жилийн ойн мадаль"-иар Я.Минжүүр, М.Эрдэнэбилэг, Д.Пунцагхорлоо, Л.Удвал, С.Ариунгэрэл, Л.Эрдэнээ, Б.Цэцэгмаа, Б.Минсэл, О.Одмандах, Г.Жамсран, О.Нямцэрэн, Л.Цэнд, Т.Адъяасүрэн, Ц.Долгор, Б.Сугармаа, Г.Цэнд, Д.Наранцэцэг, Б.Нарангэрэл, Н.Ариунсайхан, Р.Оролмаа, К.Кулимаш нарын 21 хүн шагнагдсан юм.

# ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ

ДУУЛГАХ СОНИН

## С.БАТ-ЭРДЭНЭ: "Цэргийн алдрын хөшөө"-г түшиглэн ОХУ-ын Зэвсэгт хүчний дайчдад зориулсан дурсгалын цогцолбор, бүсийн хэмжээний сургалтын төв, аялал жуулчлалын гол цэг болгох бүрэн боломжтой

Э.ТУУЛ



*Говьсүмбэр аймагт сүндэрлэн байдаг, хаа газраас ирсэн зочдын нүдийг хужирлаж, гэрэл зургаа дурсгал болгон дэргэд нь татуулдаг нэгэн сонирхолтой хөшөө дурсгал байдаг нь Зөвлөлтийн цэргийнхний байгуулсан "Цэргийн алдрын хөшөө" билээ. Тэгвэл энэхүү хөшөөг засч сэлбэн, эргэн тойронд нь аялал жуулчлалын цогцолбор байгуулах тухай яригдаад багагүй хугацаа өнгөрчээ. Манай сурвалжлах хэсэг Говьсүмбэр аймагт саатахдаа энэхүү хөшөөг аялал жуулчлалын цогцолбор болгохоор чин зүтгэлээр хөөцөлдөж яваа Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа С.Бат-Эрдэнэтэй уулзаж, цөөн хором ярилцсан юм.*





**-Аугаа их ялалтын 30 жилийн ойд зориулсан босгосон гэх "Цэргийн алдрын хөшөө"-ний талаар ярьж өгөөч?**

-1975 онд Аугаа их эх орны дайны ялалтын 30 жилийн ойд зориулан энэхүү хөшөөг босгосон түүхтэй. Эрэн сурвалжлах сэтгүүлч, зохиолч Б.Энхтөрийн эмхэтгэсэн "Чойр дахь Зөвлөлтийн цэргийн түүх" номд нэлээд дэлгэрэнгүй бичсэн байдаг. Тэрхүү эмхэтгэлд тулалдаанд цэргүүд ихээр амь үрэгдсэн газруудад "Нэр нь үл мэдэгдэх дайчиддаа" зориулсан хөшөөг босгодог байсан бөгөөд англичууд 1920 онд Лондон хотноо нэгэн том тулалдаанд үрэгдсэн нэр нь тодроогүй цэргүүдийнхээ шарилыг цугт нь мөнхөлж, анхны хөшөөг бий болгож байсан гэж тэмдэглэсэн байдаг. Харин Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт Оросын цэргүүд олноор амь үрэгдсэн тулалдаан болж байгаагүй. 1974 онд аугаа их эх орны дайны ялалтын 30 жилийн ойг угтаж, цэргүүдийнхээ алдар, байгуулсан гавьяагаар бахархаж "Цэргийн алдрын хөшөө"-г босгож байсан түүхтэй юм билээ. Манай аймагт хүйтэн дайны үе гэх 1969-1989 онд Зөвлөлтийн цэргийн 41 дүгээр мотобуудлагын дивиз Монгол Улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолыг батлан хамгаалах онцгой үүрэгтэйгээр байрлаж байсан гэж үзэж болох юм. Алба хааж байсан хугацаат цэргийн албан хаагчдаас гадна офицер, ахлагч, ажилчдын ар гэрийнхэн төдийгүй, энд төрж, өссөн, бага насаа өнгөрөөсөн олон орос иргэд байгаа учраас тэдний хувьд энэ бол түүхэн дурсгалт газрынх нь нэг юм.

**-"Цэргийн алдрын хөшөө"-г тойруулан аялал жуулчлалын цогцолбор босгох талаар нэлээд дээр үеэс яригдаж байсан гэдэг. Та энэхүү цогцолборыг байгуулах санааг гаргасан юм уу?**

-"Цэргийн алдрын хөшөө"-г зөвхөн Говьсүмбэр аймаг төдийгүй хоёр орны найрамдлын хэмжээний цогцолбор байгаасай гэж хүсч байсан учраас санааг нь гаргаж, зураг төслийг нь хийлгэсэн юм. Учир нь тухайн үед байрлаж байсан цэргүүдийн ар гэр, хойч үе нь энд ирэхэд тохитой тухтай байрлах газар алга, ирээд хөшөөний ойр орчимд жаахан гуниглаж, харж зогсож, тойрч нулмис дуслуулж байгаад л буцдаг нь анзаарагдсан. "Цэргийн алдрын хөшөө"-г түшиглэн цэргийн болоод энгийн төрөл бүрийн сургалтыг аймаг, бүсийн хэмжээнд хүлээн авч, зохион байгуулдаг сургалтын төв, нөгөө талаар аялал жуулчлалын цомхон цогцолбортой болгоод авах нь зөв гэж боддог. Цогцолбор нь тухайн үеийн Зөвлөлтийн цэргийн дивизийн түүхийг хадгалсан үзвэрийн танхим музей, зочид буудал, албан ажлын зориулалт бүхий байр, хурлын танхим, орос үндэсний хоолны газар, байлдааны болон спорт бууны буудлагын тир, авто машины дулаан зогсоол зэрэг барилга байгууламжаас бүрдэх бөгөөд гадна талбайдаа ёслол хүндэтгэлийн өргөө гэр, орос зэвсэглэл техникийн үзмэрүүдийг байрлуулахаар төлөвлөж, зураг төсөл нь бэлэн болсон. Б.Энхтөрийн эмхэтгэлд "Энгийн статистик мэдээгээр харьцуулахад жилд ОХУ-ын Буриад улсаас хамгийн багадаа 1000 жуулчин /Чойрт цэргийн алба хааж байсан халагдсан цэргүүд/ ирэх боломжтой гэдэг нь харагддаг. ЗХУ-ын хуурай замын цэргийн хугацаат цэргийн алба хоёр жил байсан гэж тооцвол эдүгээ ОХУ-д зөвхөн Чойрт алба хаасан 150-200 мянган хүн бий. Цэргүүдээс гадна офицерийн бие бүрэлдэхүүн, гэр бүл, үр хүүхэд, мэргэжилтнүүд гээд тооцвол бүр ч нэмэгдэнэ" гэж бичсэн байдаг. Өнөөдрийн байдлаар Мотобуудлагын 41 дүгээр дивиз байрлаж байсан барилга, байгууламжийн зарим хэсэгт аймгийн нутгийн удирдлагын ордон, айл өрх, албан байгууллагууд байрлаж үйл ажиллагаагаа хэвийн явуулдаг төдийгүй улсын хэмжээнд манай аймгийн нийт айл өрхийн 60-65 хувь нь орон сууцанд амьдардаг гэсэн өндөр үзүүлэлт бүхий судалгаа байгаа нь Оросын дивиз байрлаж байсны ач тус гэдгийг орон нутгийн удирдлага, ард иргэд хэзээ ч мартахгүй өнөөдрийг хүрсэн юм.

...Энэхүү хөшөөг түшиглэн гадаадын жуулчдыг татах талаар Орон нутгийн хөгжлийн бодлогод тусгагдаад явж байгаа хөрөнгө санхүүгийн асуудлаас болоод сайн шийдэлд хүрч чадахгүй байгаа юм...

**-Бүх зүйл төсөв хөрөнгөгүй бол шийдэгддэггүй. Энэ талаар ОХУ-ын талаас дэмжлэг үзүүлэх боломж байдаг юм болов уу?**

-Цогцолбор байгуулах талаар санал хүсэлтээ орон нутагт ажлаар ирсэн ОХУ-ын зочид төлөөлөгчдөд үзүүлж, танилцуулсаар ирсэн. Үзсэн хүмүүс ч сайхан санаачилга байна гэж ам сайтай байдаг. Өмнө нь Монгол Улс, ЗХУ-ын баатар, Монгол Улсын сансарын нисэгч хошууч генерал Ж.Гүррагчаа гуайг урьж ирүүлж үзүүлсэн, үзээд дэмжиж байгаагаа илэрхийлсэн. ОХУ-ын ЭСЯ-ны цэргийн атташе ч ирж, үзсэн дэмжиж байна гэсэн. Тэгэхдээ бүх л зүйл хөрөнгө мөнгөний асуудалтай холбогддог. Ерөнхийдөө бид төсвийн тооцоогоо гаргачихсан байгаа. Хэдийгээр энэхүү хөшөөг түшиглэн гадаадын жуулчдыг татах талаар Орон нутгийн хөгжлийн бодлогод тусгагдаад явж байгаа хөрөнгө санхүүгийн асуудлаас болоод сайн шийдэлд хүрч чадахгүй байгаа юм. Ямартай ч, хөрөнгө мөнгөний асуудал шийдэгдчихвэл орон нутагт бүсийн хэмжээний сургалтын төв, аялал жуулчлалын гол цэг бүхий сайхан дурсгалт газар болно гэдэгт найдаж байна.

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр +22
Шөнө +10

Нөгөөдөр

Өдөр +17
Шөнө +9

### Өдрийн зурхай

**НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ЦАГААН БАР ӨДӨР**

**Үс засуулбал:** *Эрч хүч ихэснэ.о.*

**Наран ургах, шингэх:** *06.13-19.35*



Тухайн өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба хараал, жатхыг буцаах, амьлуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, бомбын үйл, бэрийн үйлд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч, хүч ихсэнэ.

## "ЭРҮҮЛ АМЬДРАЛ" явган аялалд нэгдлээ



Нийгмийн амьдралд тэр бүр идэвхтэй оролцож чадалгүй, гадна үлддэг хүмүүс бол зорилтот бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг. Харин энэ байдлыг халах зорилгоор төлөвлөж, зохион байгуулж буй олон ажлуудын нэг нь энэ сарын 23-ны өдөр Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Эрүүл амьдрал" явган аялал байлаа. Тус аяллыг аймгийн ИТХ, Засаг даргын тамгын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Дуу бүжгийн "Боржигин" чуулга, Нефть хангамжийн газар дэмжиж, хамтран ажиллалаа.

Аялалд оролцсон 70 гаруй иргэн Чойрын богд уулаараа аялж, Цагаан дарь эх бурхандаа мөргөж, Цоорхойн рашаанаараа ундаалан, урлаг, спортын үзүүлбэрээр өрсөлдөн, 4, 5, 6 дугаар багийн иргэдээс бүрдсэн "Манлай 15" баг тэргүүллээ. Мөн АХА тэмцээнд тус сумын 3 дугаар багийн иргэн Т.Лхамжав тэргүүн, 5 дугаар багийн иргэн Ш.Оюунцэцэг дэд байр эзэлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнагдсан. Энэхүү арга хэмжээ нь иргэдийн сэтгэлд нийцсэн, цаг үе, эздээ олсон арга хэмжээ байлаа. Зорилтот бүлгийн иргэд биеийнхээ чилээг гаргаж, сэтгэлийнхээ галыг бадрааж, оюуныхаа цангааг тайлж, нэг өдрийг инээд хөөртэйгөөр хамтдаа өнгөрүүлсэндээ баяртай байлаа. Нэг өдрийн арга хэмжээгээр олон өдрийн эрч хүчээ авч чадсан нь иргэдийн сэтгэл ханамжаас илэрхий байв. Цаашид зөвхөн нэг өдрийг зориулж, арга хэмжээ зохион байгуулах биш өдөр бүр өөрсдийг нь нийгэмд хэчнээн үнэ цэнэтэй болохыг мэдрүүлж, дэмжсэн олон ажлыг зохион байгуулна гэдгээ албаны хүмүүс хэлж байлаа.

## Аймгийн арслан Э.МӨНХБААТАРЫН цолны мялаалга НААДАМ БОЛОВ

Тулгар төрийн 2226, Их Монгол Улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Говьсүмбэр аймгийн баяр наадамд амжилттай барилдаж түрүүлсэн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харъяат, аймгийн арслан Э.Мөнхбаатарын цолны мялаалга наадам Сүмбэр сумын V багийн нутаг Баруун-Өвөрт боллоо. Цолны мялаалга наадамд их нас, соёолон насны морьдын уралдаан болж, үндэсний бөхийн барилдаанд, өсвөрийн бөхийн барилдаан зохион байгуулагдсан юм. Наадмыг нээж, аймгийн ажиллагаа уртаас урт үргэлжлэн хамгийн сүүлд хамт бэлтгэл хийж барилддаг бөхчүүд нь хүндэтгэл үзүүлснээр өндөрлөсөн юм. Мөн шинэ арслан Э.Мөнхбаатар маань тусгайлан гэр бэлтгэж ирсэн зочид гийчид нутгийн иргэдээ хүлээн авч хүндэтгэл үзүүлж байлаа. Үндэсний бөхийн барилдаанд хүчит 32 бөх барилдаж, Сүмбэр сумын харъяат аймгийн арслан Б.Үүрцайх түрүүлж, аймгийн арслан Б.Гончигтавхай үзүүрлэлээ. Шөвгийн дөрөвт Сүмбэр сумын харъяат, аймгийн



Засаг дарга Г.Батсуурь үг хэлж шинэхэн арсландаа бэлэг өгөх үйл ажиллагаа эхэллээ. Хамгийн түрүүнд аймгийн Засаг дарга Г.Батсуурь, ИТХ-ын дарга Г.Батзам нар өргөмжлөл, дурсгалын зүйл гардуулан өгсөн бол Э.Мөнхбаатарын өвөө, эмээ, ах дүү хамаатан садан, нутаг усныхан, найзууд, үндэсний бөхийн холбоо, бөх сонирхогчдийн төлөөлөл гээд шинэ арсландаа бэлэг өгөх заан А.Амартөр, Дундговь аймгийн Баянжаргалан сумын харъяат, аймгийн заан Н.Наранбаяр нар шалгаран үлдэж үзэгч түмнээ баясгасан байна. Хурдан их насны уралдаанд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харъяат, аймгийн алдарт уяач Ц.Энхжаргалын толин хүрэн морь түрүүлсэн бол соёолонгийн уралдаанд Сүмбэр сумын харъяат, Т.Шижирын зээрд соёолон түрүүлжээ.